



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2019 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

**Малын удмын сангийн үндэсний төв, аймгууд дахь
цөм сүргийн салбар нэгжүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын дүнг хэлэлцсэн тухай**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай” А-72 дугаар тушаалын хүрээнд Малын удмын сангийн үндэсний төв, аймгууд дахь Цөм сүргийн үржлийн салбар нэгжийн 2016-2018 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтэй танилцав.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Малын удмын сангийн үндэсний төв, аймгууд дахь цөм сүргийн салбар нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, ажлын үр дүнгээр холбогдох байгууллагуудад өгөх зөвлөмжийг нэгээс хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Зөвлөмжийн заалтын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Т.Жамбалцэрэн/, Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Малын генетик, нөөцийн хэлтэс /Д.Батсүрэн/, Малын удмын сангийн үндэсний төв /Д.Цолмон/-д тус тус үүрэг болгосугай.

3. Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Т.Жамбалцэрэн/, Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Малын генетик, нөөцийн хэлтэс /Д.Батсүрэн/, Малын удмын сангийн үндэсний төв /Д.Цолмон/-д тус тус даалгасугай.

4. Зөвлөмжийн хэрэгжилтийг хяналтад авч, дотоод аудитын хорооны хурлаар хагас, бүтэн жилээр хэлэлцүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ч.Тавинжил/-д үүрэг болгосугай.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА** **Ч.УЛААН**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн
ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын
хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01
дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

МАЛЫН УДМЫН САН ҮНДЭСНИЙ ТӨВ, АЙМГУУД ДАХЬ ЦӨМ СҮРГИЙН САЛБАР НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай” А-72 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Малын удмын сангийн үндэсний төв, аймгууд дахь Цөм сүргийн үржлийн салбар нэгжийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

1. Цөм сүргийн үржлийн салбар нэгжийг удирдлага зохион байгуулалт, менежментийн хувьд зөв зохистой ажиллаж болох хувилбарыг судлаж, МУСҮТ болон аймгийн ХХААГ-ын аль нэг харьяанд шилжүүлэх асуудлыг бодлогын түвшинд холбогдох хууль, эрхзүйн хүрээнд нийцүүлэн судалгаа, шинжилгээнд үндэслэн шийдвэрлэх

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

1. Худалдан авалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Сангийн сайдын 2017 оны 07-р сарын 04-ний өдрийн 234-р тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын мөрдөж, гүйцэтгэлийн баталгааг байршуулан, нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажлын үр уялдуулан чөлөөлөх асуудлыг зохион байгуулж байх;

2. МУСҮТ-ийн Шувуун фабрикт байрлах 44,872.0м² газрыг Хөрөнгийн үнэлгээний хуулийн 8.1 “Хөрөнгийн үнэлгээг тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартын дагуу хийх” дэх заалтын хүрээнд дахин үнэлгээ хийгдсэн эсэх нь тодорхойгүй тул мэргэжлийн үнэлгээний байгууллагаар дахин үнэлгээ хийлгэх асуудлыг судалж шийдвэрлэх;

3. МУСҮТ нь Цөм сүргийн малыг бараа материалын тайланд бүртгэсэн нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны 411 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт” болон УСНББОУС-27 Хөдөө, аж ахуйн стандартад тусгагдсаны дагуу Цөм сүргийн үржлийн нэгжийн мал сүргийг “Үржлийн биологийн хөрөнгө”, “Таваарын биологийн хөрөнгө”-ийн ангиллаар салгаж бүртгэх асуудлыг салбарын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т тусгах;

МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

1. Цөм сүргийн үржлийн салбар нэгжийг удирдлага зохион байгуулалт, менежментийн хувьд зөв зохистой ажиллаж болох хувилбарыг МУСҮТ, аймгийн ХХААГ-ын аль нэг харьяанд шилжүүлэх асуудлыг бодлогын түвшинд холбогдох хууль, эрхзүйн хүрээнд нийцүүлэн судалгаа, шинжилгээнд үндэслэн шийдвэрлэх

2. Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон, зээлийн төлбөрт хүлээн авч байгаа малын үйлдвэрлэг байдалд дүгнэлт гаргуулж, дүгнэлтэд тохирсон үнэ ханш, хэрэгцээ шаардлагад үндэслэн худалдан авалт хийх, Гачуурт ХХК-тай байгуулсан гэрээг

дүгнэхдээ нийлүүлж буй малын үнэ ханшийг үүлдэрлэг байдалтай уялдуулан тохирох. Хэрэгцээ шаардлагад нийцэхгүй малыг гэрээний өрөнд авдаг байдлыг таслан зогсоох

МАЛЫН ГЕНЕТИК, НӨӨЦИЙН ХЭЛТЭСТ

1. Цөм сүргийн үржлийн салбар нэгжийг удирдлага зохион байгуулалт, менежментийн хувьд зөв зохистой ажиллаж болох хувилбарыг МУСҮТ, аймгийн ХХААГ-ын аль нэг харьяанд шилжүүлэх асуудлыг бодлогын түвшинд холбогдох хууль, эрхзүйн хүрээнд нийцүүлэн судалгаа, шинжилгээнд үндэслэн шийдвэрлэх

ХУУЛИЙН ХЭЛТЭС

1. Худалдан авалтын үйл ажиллааг удирдан зохион байгуулахдаа Сангийн сайдын 2017 оны 07-р сарын 04-ний өдрийн 234-р тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий гэрээ байгуулах журам”-ын мөрдөж, гүйцэтгэлийн баталгааг байршуулан, нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажлын үр дүнд уялдуулан чөлөөлөх асуудлыг зохион байгуулж байх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн
ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын
хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01
дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

МАЛЫН УДМЫН САН ҮНДЭСНИЙ ТӨВ, АЙМГУУД ДАХЬ ЦӨМ СҮРГИЙН САЛБАР НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн “Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай” А-72 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Малын удмын сангийн үндэсний төв, аймгууд дахь Цөм сүргийн үржлийн салбар нэгжийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

1. Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, орон тоог дахин хянах, шинэчлэн боловсруулж, архивын нэгж бүрдүүлэх,

2. Тус төвийн малчидтай байгуулж буй хөдөлмөрийн гэрээний загварыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд нэг загварт оруулж, тухайн орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулж шинэчлэн боловсруулж байгуулах, дүгнэх,

3. Малын үндэсний генийн санг хамгаалах, гойд ашиг шимт цөм сүрэг, цэвэр үүлдрийн донор болон тээгч малыг байршуулж ашиглах, бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд хамруулах, ялган тэмдэглэх,

4. Цөм сүргийн салбар нэгжийн үйл ажиллагааны менежментийг оновчтой болгож, малын тоо толгойг зохистой харьцаанд барьж, үүлдэрлэг шинжийг хадгалсан сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгчийг үржүүлэх, үржилд нийлүүлэх,

5. Малын генетик чадавхийг нэмэгдүүлэх, аж ахуйн зохион байгуулалтыг бэхжүүлэх, гадаадын төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагуудтай хамтран техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг авах, малчин, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, сургалтад хамруулах,

6. Малчид болон халагдаж, солигдсон менежерүүдтэй хийх малын өр, авлагын тооцоог хийж, барагдуулах,

7. Генийн санг шинээр баригдсан Дарханы МУСҮТ-ийн цогцолборт нүүлгэн шилжүүлж, холбогдох стандартын дагуу зориулалтын байранд хадгалж, хамгаалах, зарцуулах,

8. Генийн санд хадгалагдаж буй нутгийн болон импортын үрийг төрөлжүүлэн Үржлийн бухны үр. MNS1633:1972, Үржлийн хуцны үр. MNS1634:1972, Үржлийн ухны үр. MNS1635:1972, Хуцны хөлдөөсөн үр. Техникийн шаардлага. MNS4876:1999, Ухны хөлдөөсөн үр. Техникийн шаардлага. MNS4989:2000, Монгол азарганы хөлдөөсөн үр. Техникийн шаардлага. MNS5262:2003, Мал аж ахуй. Араб азарганы хөлдөөсөн үр. MNS5931:2008 стандартын дагуу хадгалах, хамгаалалтын бүс/зон/ бий болгох, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээний мэдээлэл тавих, тусгай эрх бүхий мэргэжилтэн хянаж нэвтрүүлдэг байх талаар байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх,

9. Генийн санд нэг дор төрөл бүрийн малын болон ашиг шимийн чиглэлийн үр хадгалагдаж байгаа тул үүнд онцгой анхаарч эрүүл ахуйн байдлыг хянах, дюарь сав бүрт үрийн гэрчилгээ бүхий таних тэмдэг наах нь зүйтэй. Үрийг нөөцөд байх, сургалтад ашиглах, хэрэгцээнд ашиглах зэргээр тус тусад нь дюарь саванд байлгах,

10. Генийн санд батлагдсан болон устаж болзошгүй үүлдэр омгийн малын гүн хөлдөөсөн үрийг стандартын дагуу авч хадгалах,

11. Азот нэрэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийг технологийн дагуу ажиллуулах, азот үйлдвэрлэлийг тогтмолжуулах,

12. Шувуун фабрик дахь МУСҮТ-ийн хуучин байрыг шинэчлэн засварлаж, үйл ажиллагаанд оруулж ашиглах,

13. Үржлийн малд үзлэг ангилалт хийхэд шаардагдах зоо багаж, тоног төхөөрөмжөөр хангах,

14. Малын гарваль, ашиг шим, орлого, зарлагын нэгдсэн бүртгэлийн дэвтэртэй болгох, Сүргийн бүтцийг зөв гаргах талаар сургалт, мэдээллээр хангах,

15. Цөм сүргийн нэгжийн мал маллаж буй малчинд өвс, тэжээлийн нөөцийг хангалттай хэмжээгээр бүрдүүлж ажиллах шаардлагатай

16. Сэлэнгэ, Булган, Өмнөговь, Хэнтий, Дундговь, Сүхбаатар, Дорнод аймгуудын цөм сүргийн үржлийн төвд үржүүлж буй мал сүргийг үүлдэрлэг байдал, ашиг шимийн түвшинг бууруулахгүй байхад онцгой анхаарч, сүрэг сэлбэх болон сайн чанарын хээлтүүлэгчээр одоо байгаа суурьт сайжруулалт хийх;

17. Баянхонгор, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дорнод Увс аймгийн ЦССН-ийг нэгжийг татан буулгаж, улсын бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулах

18. Жи-Си-Эс ТББ-д бүртгүүлсэн 11.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 авто машиныг байгууллагынхаа бүртгэлд тусган ашиглалтад хяналт тавьж ажиллах

19. Дундговь аймгийн ЦССН-ийн менежер С. Хорлоогоос дутагдсан 16 толгой хонь, Хэнтий аймгийн ЦССН-ийн менежер Я. Бямбацогтоос дутагдсан 31 толгой хонь, нийт 47 толгой хонийг төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох ажлыг зохион байгуулах

20. Өмнөговь аймгийн ЦССН-ийн менежер Цэцэг-Өлзийгөөс 705.4 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж болох хатаах шүүгээ, Дундговь аймгийн ЦССН-ийн менежер Хорлоогоос ажил хүлээлцэхэд аваагүй гэдэг шалтгаанаар 360.0 мянган төгрөгийн худгийн насос, нийт 1065.4 мянган төгрөгийн хөрөнгийг дээрх албан тушаалтнуудаар төлүүлэх

21. ТӨХ-ний 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 193 тогтоолоор МУСҮТ-д шилжүүлсэн 89.7 сая төгрөгийн хөрөнгөнөөс одоо хүртэл бүртгэл тайланд тусаагүй 61.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагад шилжүүлэх болон буцаах талаар арга хэмжээ авах

22. Хөрөнгийн үнэлгээний хуулийн 8.1-д Хөрөнгийн үнэлгээг тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартын дагуу хийх” заалтын хүрээнд дахин үнэлгээг хийгээгүйгээс 287,2 сая төгрөгөөр үнэлэгдэх газар 53,8 сая төгрөгөөр үнэлэгдэн асуудлыг судлан, дахин үнэлгээ хийлгэх асуудлыг шийдвэрлэх

23. МУСҮТ-ын Цөм сүргийн малыг бараа материалын тайланд бүртгэсэн нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны 411 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт” болон УСНББОУС-27 Хөдөө, аж ахуйн стандартад тусгагдсаны дагуу Цөм сүргийн үржлийн нэгжийн мал сүргийг “Үржлийн биологийн хөрөнгө”, “Таваарын биологийн хөрөнгө”-ийн ангиллаар салгаж бүртгэх асуудлыг зохион байгуулах

24. Байгууллагын өмч хөрөнгийг эзэмшигч бүрээр бүрэн картлан гарын үсэг зуруулан баталгаажуулж хүлээлгэн өгөх, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

25. Өр авлагыг барагдуулах төлөвлөгөө боловсруулан, өр авлагыг бүрэн барагдуулах

26. МУСҮТ-ийн захирлын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Үрийн үнийг шинэчлэн тогтоосон” А-39 тушаалыг өөрчилж, үрийг борлуулалтаас дахин алдагдал хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

27. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлэн, холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж ажиллах

28. Эд хариуцагч солигдсон тухай бүр ажил хүлээлцүүлэхдээ, хөрөнгө, мал амьтныг нэгбүрчлэн тоолж хүлээлцэх, эд хариуцагч нартай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллах.